



ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЙРАГ СУМЫН БАЙРНЫ  
ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ТЕХНИКИЙН ДААЛГАВАР  
*/д/ ХУУДАС/*

ТАНИЛЦСАН:

А.ГАНТУЛГА  
ТЕХНОЛОГИЙН УДИРДЛАГА,  
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ

Ц.ОДХҮҮ  
СТРАТЕГИ, САНХҮҮ БОРЛУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ

ХЯНАСАН:

С.ЗОЛЖАРГАЛ  
ДЭД БҮТЭЦ ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:

Н.ИЧИНХОРЛОО  
ДЭД БҮТЭЦ ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024.01.05.

- 1. Барилга байгууламжийн байршил:** Дорноговь аймаг, Айраг сум, 4-р баг, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн салбарын байр.
- 2. Ажлын зориулалт:** Барилгын их засварын ажил
- 3. Барилгын ерөнхий үзүүлэлт:** 1989 онд ашиглалтанд орсон нийт 64 м.кв талбай бүхий 2.4 м өндөр, 500 мм-ын зузаан чулуун дүүргэгч ханатай, бетон суурьтай, модон хучилттай дээвэр бүхий төвлөрсөн дулаан, цэвэр бохир усны шугаманд холбогдоогүй, 1 давхар жижиг барилга
- 4. Гүйцэтгэгчид тавигдах ерөнхий шаардлага:**
  - 4.1. Засварын ажлыг дулааны улиралд чанарын өндөр түвшинд, ажлын тоо хэмжээ зураг төсөвт тусгасаны дагуу хийж гүйцэтгэх шаардлагатай.
  - 4.2. Засварын ажлыг гүйцэтгэхдээ БНБД 31-10-05 (Заслын ажил), БНБД 31-07-05 (Дээврийн ажил), БНБД 31-08-05 (Дуу, дулаан тусгаарлалтын ажил) болон бусад шаардлагатай норм стандартыг мөрдлөг болгоно.
  - 4.3. Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, БНБД стандарт шаардлагад нийцүүлэн, технологийн дагуу, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
  - 4.4. Барилгын ажилд шаардлагдах материал, тоног төхөөрөмж нь Монгол улсын стандарт, чанарын шаардлага хангасан байх ба захиалагчаар хянуулна. (Барилгын тухай хуулийн 13 дугаар зүйл заалтууд, 40.1.20)
  - 4.5. Гүйцэтгэгч нь ажиллагаатай байгаа техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг алдагдуулахаас сэргийлж зайд тэжээл, тоног төхөөрөмжийн өрөөг тур битүүмжлэх, тоос шороо доргилтоос хамгаалах арга хэмжээг урьдчилан авна. Ажил гүйцэтгэх явцад кабель таслах болон тоног төхөөрөмжид гэмтэл саатал гаргасан тохиолдолд үссэн хохирлыг бүрэн хариуцна.
  - 4.6. Ажлыг гүйцэтгэхдээ тухайн байршилд ажил үйлчилгээ явуулж байгаа бусад байгууллагуудад саад бэрхшээл учруулахгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэн талбайн зохион байгуулалтыг хийж ажиллах шаардлагатай.
  - 4.7. Ажил гүйцэтгэх явцад талбайд ажиллаж буй ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажиллах ба үүнээс гарах хор хохирлыг өөрсдөө хариуцна. Барилга угсралтын ажилд мөрдөх аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн заавар БД 12-101-05-ийг хангаж ажиллана.
  - 4.8. Галын аюулгүй ажиллагааны БНБД 21.02.02, БНБД 21.01.02 дүрэм журам, стандартыг хангасан байна.
- 5. Барилгын ажил болон гүйцэтгэгчид тавигдах бусад шаардлага:**
  - 5.1. Засварын ажлыг өгөгдсөн ажлын тоо хэмжээний дагуу сайн чанарын материал ашиглан чанарын өндөр түвшинд гүйцэтгэх ба гадна фасад болон дотор өрөө тасалгааны өнгө загварыг захиалагчтай урьдчилан зөвшилцнө.
  - 5.2. Барилгын гадна талаар тоосгон хана өрж, бороо усны хамгаалалт, хаяавч хийнэ.
  - 5.3. Хөөснөнцөр дулаалгатай төмөр сэндвич хавтангаар дээвэр хийнэ.
  - 5.4. Хаалга цонхны гадна ханатай харьцах хэсгийг шингэн хөөсөн дулаалгаар сайтар чигжиж, амалгаа хийхдээ MNS6266:2011 стандартыг мөрдөнө.
  - 5.5. Барилгын үүдний хэсгийн хуучин тамбурыг буулгаж шинээр өрдийн тоосгоор энгийн гоёлтой 250 мм-ийн тоосгон хана өрнө.
  - 5.6. Дотор хананд сайн чанарын эмульсэн будаг бт-177 ашиглана. (галаас хамгаалах)

- 5.7. Ажлын явцад гарсан хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хаях ба ажил дууссаны дараа талбайг цэвэрлэж хүлээлгэн өгнө.
- 5.8. Барилгын засварын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
- 5.9. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, фото зургаар баталгаажуулсан байна.

#### Засварлах барилгын фото зураг

